



Бөхөнгийн Мэдээ



2005 өвөл: дугаар 3

Зураасан зургийг Владимир Смирин

Бөхөнгийн экологи, хамгааллын талаар мэдээлэл, санал солилцох 6 хэл дээр эрхлэн гаргаж буй хэвлэл

Агуулга

Сэдэвт өгүүлэл –1 хуудас

Э.Ж.Милнер-Гулланд, Анна Лушечкина. Яцкулын бөхөн үржүүлэх төвийн зочдын танхимын нээлт

Шинэ мэдээ –2-3 хуудас

Бөхөн хамгаалах холбоо байгуулагдав
Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцийн амжилт – 2006 оны 9-р сард Алматад болох хурал
Узбекистан бөхөн хамгаалах харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурав
Ростовын байгалийн нөөц газрын олон улсын хуралд бөхөнгийн талаар дурдав
Халимагт “Талын мастер” тэмцээн болов
Бөхөнгийн тухай кино шагнал хүртжээ
Хятадын телевизээр үзүүлсэн бөхөнгийн тухай мэдээлэл
Үр бүтээлтэй хяналт шалгалт
Узбекистаны хилийн харуулууд хулгайн анчинг илрүүлэв
Үргэнчид хулгайн анчид бөхөнгийн мах зардаг

Хэвлэлийн тойм –3-4 хуудас

Б.Убуцаев. Ирээдүйгээ буудаж байна. Известия Калмыки, N 46, 2006 оны 2 сарын 1
Ж.Байгуринов. Жемийн ойролцоо бөхөн байхгүй. Казахстанская Правда. Дугаар 8-89, 2006 оны 4 сарын 14

Эрдэм шинжилгээний өгүүлэл – 4-7 хуудас

Ли Лишу. Хятадад бөхөн сэргээн нутагшуулах боломжтой нөөц газар
Ким ба Жоел Бергер. Монгол бөхөн: Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс
А.Д.Липкович. “Тал хээрийн зэрлэг амьдрал” нийгэмлэгийн үржүүлэх төвд бөхөнг гаршуулан тэжээж буй ажлын туршлага
Е.Быкова, А.Есипов, Р.Мурзаханов. Устюрт дахь шингэн хийн ашиглалт: Бөхөнд шинэ аюул занал болох уу?

Төслийн эргэн тойронд – 7-8 хуудас

Орлого олох гар урлалын төсөл Халимагт хэрэгжив.
Бид ертөнцийг илүү сайн, эелдэг болгох ёстой –Халимаг дахь TNT төсөл
Оросын бөхөн хамгаалалд АНУ тусалдаг
Халимаг дахь Дарвины санаачлагын шинэ төсөл
Сүүлийн үед хэвлэгдэн гарсан бөхөнгийн талаарх хэвлэлүүд

Яцкулын бөхөн үржүүлэх төвийн зочдын танхимын нээлт

Оросын холбооны улсын Халимагын бүгд найрамдах улсын ерөнхийлөгч Кирсан Илюмжинов Халимагийн Яцкул дүүрэг дахь Зэрлэг амьтдын төвийн зочдын танхимыг 2006 оны 5 сарын 15-нд албан ёсоор нээв. Зэрлэг амьтдын төвийн захирал Ю.Н.Арылов ба түүний эрдэм шинжилгээний ажилчдын нөр их хөдөлмөр, хүчин чармайлтаар энэ жил нээлтээ хийлээ. Орон нутгийн сургуулийн багш, сурагчид ардын дуу дуулж, бүжиг бүжиг. Халимагт бөхөнгийн баярыг ирэх жил тэмдэглэх тухай ерөнхийлөгч албан ёсоор мэдэгдэв.



Зураг. Ерөнхийлөгч К.Илюмжинов, доктор В.Неронов нар тууз хайчилж байна. Зургийг Э.Ж.Милнер-Гулланд



Зураг 2. Бүжигчид зочдын танхимын гадна талд давтлага хийж буй нь. Зургийг Э.Ж.Милнер-Гулланд

Зочдын танхим нь бөхөнгийн экологи, хамгааллыг харуулсан үзүүлэн, Халимагийн соёл, ёс заншлын үзмэр, компьютерийн хэрэгсэл зэргээр хангагдсан. Үржлийн төв нь судлаачдад зориулсан багаж хэрэгсэл, сургуулийн хүүхдүүдэд зориулсан танхимтай. Орон нутгийн болон олон улсын боловсролын байгууллагуудтай нягт холбогдсон төдийгүй бөхөнгийн зан төрхийн талаар ажиглалт судалгаа хийх, тэжээн үржүүлэх арга техникт суралцах үйл ажиллагаа явуулах боломжтой.

Зэрлэг амьтдын төв нь бөхөн гаршуулан үржүүлж буй дэлхийд тэргүүлэгч байгууллага бөгөөд түүний дадлага туршлага хэрэгцээ шаарлагаа даган өсөж байна.

Төв нь үйл ажиллагаагаа Халимагийн байгаль орчны боловсрол, үйл ажиллагааны төв болох зорилготойгоор цаашид үргэлжилнэ. Олон улсын олон байгууллага санхүүгийн тусламж үзүүлдгийн тоонд Английн засгийн газрын Дарвины санаачлага, SEPS, Том өвсөн тэжээлтэн амьтдын сан, Америкийн загас, зэрлэг амьтдын алба, Денверийн амьтны хүрээлэн, Амьтны хүрээлэнг дэмжих сан, Колорадогийн амьтны хүрээлэн, ITERA, TNT экспресс.



Зураг 3. Халимагийн ерөнхийлөгч Зэрлэг амьтдын төвийн захиралтай бөхөн хамгааллын талаар ярилцаж байна. Зургийг Э.Ж.Милнер-Гулланд

Э.Ж.Милнер Гулланд, Лондоны эзэн хааны колледж, Анна Лушечкина, UNESCO/ MAB. Илүү мэдээлэл авахыг хүсвэл: <http://saigak.biodiversity.ru/news/250506.html> хаягаар хандана уу.

Редакцийн зөвлөл. Хятад: Доктор А.Канг, WCS-ын Хятад дахь салбар (ygling@online.sh.cn); Казахстан: Профессор А.Бекенов, доктор Лу.А.Грачев, Амьтан судлалын хүрээлэн (terio@nursat.kz); Монгол: доктор Б.Лхагвасүрэн, Доктор Л.Амгалан, Биологийн хүрээлэн (ecolab@magicnet.mn), . Онон, WWF Mongolia, (anon@wwf.mn); Орос: Профессор Ю.Арылов, Халимаг улсын Зэрлэг амьтны төв, доктор А.А.Лушечкина, Эволюци ба экологийн хүрээлэн (mab.ru@relcom.ru); Туркменистан: Доктор Д.Сапармуратов, Цөлийн амьтан, ургамлын хүрээлэн (desert@online.tm; saparmuradov@mail.ru); Узбекистан: Доктор Е.Быкова, доктор А.Есипов, Амьтан судлалын хүрээлэн (esip@tkt.uz); Нэгдсэн вант улс: Доктор Е.Ж.Милнер-Гулланд, Лондоны эзэн хааны колледж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Бөхөнгийн талаарх мэдээ, материалыг 6 хэл дээр хүлээн авна. Мэдээ, материалуудаа esip@tkt.uz хаягаар илгээх эсвэл редакцийн зөвлөлийн гишүүдийн хаягаар хандаж болно. Бид жилд хоёр дугаар гаргана.

Хэвлэгдсэн нийтлэлүүдийг <http://saigak.biodiversity.ru/publication.html> юмуу www.iccs.org.uk/saiganews.html хаягуудаар нэвтрэн орж pdf файл хэлбэрээр авах ба хэвлэлийн эхийн хуулбарыг Англи, Орос, Хятад, Монгол, Казах, Узбек хэл дээр авч болно.



Шинэ мэдээ

ОЛОН УЛСЫН БОЛОН БУС НУТГИЙН

Бөхөн хамгаалах холбоо байгуулагдав

Бөхөн хамгаалах холбоо нь бөхөн хамгаалах судлах ажилд 15-аас дээш жил хамтран ажилласан судлаач хамгаалагчдын чөлөөт сүлжээ юм. Төв Ази, Каспийн орчмын тал хээрт бөхөн сэргээн нутагшуулах, тус амьтны нийгэм, эдийн засгийн үнэ цэнэ, тал хээрийн экосистемд бөхөнгийн гүйцэтгэх үүрэг зэргийг орон нутгийн иргэдэд таниулах үйл ажиллагааг явуулж байна. Бид бөхөнгийн талаарх туршлага, хамгаалах саналаа чөлөөтэй хуваалцан хамтран ажилладаг. Бид өөрсдийн үйл ажиллагаагаа засгийн газар, хамгааллын нийгэмлэг, дэлхий нийтийн өргөн хүрээнд ухуулан таниулдаг.

Бөхөн хамгаалах холбоо нь гишүүдэд нээлттэй албан ёсны бус байгууллага байна. Өөрөөр хэлбэл бид ажлын уялдаа холбоогоо таниулан, сайжруулах, хамгааллын үйл ажиллагааны ач холбогдлын дарааллыг бий болгох, хамгийн сайн санхүүгийн эх үүсвэрийг олох зэрэгт тусална. Дараах вэбсайтад хандан мэдээлэл авна уу <http://www.iccs.org.uk/SaigaAlliance.htm>. Бөхөнгийн мэдээ сэтгүүл нь Бөхөн хамгаалах холбооны нэг үйл ажиллагаа юм. Хэрэв та тус холбоонд элсэхийг хүсвэл бидэнд мэдэгдэнэ үү.

Саяхан бөхөн хамгаалах холбоо хамгийн эхний тэтгэлэгийг аваад байна. Тус тэтгэлэг Зэрлэг амьтан хамгаалах сүлжээнээс гарсан бөгөөд Елена Быкова 2006 оны 10 сард Сан Хосед болох Зэрлэг амьтдыг хамгаалах экспод Узбекистан дахь бөхөн хамгааллын талаар өөрийн ажлаа танилцуулна.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Э.Ж.Милнер Гүлланд (Лондоны эзэн хааны колледж)

e.j.milner-gulland@imperial.ac.uk, Елена Быкова (Узбекистаны Амьтан судлалын хүрээлэн) esip@tkt.uz нартай холбогдоно уу.



Нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцийн үйл ажиллагаа – 2006 оны 9-р сард Алматыд болох хурал



Казакстаны Хөдөө аж ахуйн яамны ой, агнуурын хороо "Бөхөнгийн (Saiga tatarica tatarica) зохистой хэрэглээ, сэргээн нутагшуулалт" сэдэвт хамгаалахад чиглэгдсэн харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурах анхны хурлыг зохион байгуулах болсныг CMS болон CITES та бүхэнд мэдээлж байгаадаа таатай байна. Хурал 2006 оны 9 сарын 25-26-нд Казакстаны Алматыд болно. Таныг эсвэл танай байгууллагыг тус хуралд оролцохыг урьж байна. Харилцан ойлголцлын гэрээний хурлын баримт бичиг, урьдчилсан бүртгэлийн загварыг CMS-ийн электрон хуудсаас авах боломжтой <http://www.cms.int/bodies/Agreement MoU Meetings.htm>. Бүртгэлийн эцсийн хугацаа 2006 оны 6 сарын 30.

Хурлын зорилго нь:

1. Тус тусын нутаг дахь бөхөн хамгааллын байдлын талаар мэдээлэл солилцох
2. Харилцан ойлголцлын гэрээ, үйл ажиллагааны төлөвлөгөөний тойм болон ирээдүйн нэн тэргүүний үйл ажиллагааг тодорхойлох
3. Харилцан ойлголцлын гэрээний дагуу тайлан бичих хэв загварыг батлах
4. Харилцан ойлголцлын гэрээг зохицуулах механизмын талаар хэлэлцэх зэрэг болно.

CMS болон CITES харилцан ойлголцлын гэрээний хуралтай хамтран ажиллагсдын санаачлага, техникийн зөвлөгөөнийг мөн хуралдуулахаар төлөвлөөд байна. IUCN-ийн зүйлийг хамгаалах комиссийн зэргийн мэргэжилтний бүлэг болон Европын зохистой хэрэглээний мэргэжилтний бүлэг энэ хурлыг хамтран зохион байгуулна. Зөвлөгөөн 2006 оны 23-24-нд болно. Тус зөвлөгөөнд оролцохоо урьдчилсан бүртгэл дээр тэмдэглээрэй.

Зөвлөгөөн, хамтран ажиллагсдын санаачлага дараах зорилготой:

1. Бөхөнгийн хамгааллын статусын тойм
2. Бус нутгийн хэмжээний бөхөнтэй холбоотой төсөл, үйл ажиллагааны талаар хүснэгтэлсэн хураангуй гаргах
3. Дунд хугацааны олон улсын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэслэл болох ажлын нэн тэргүүний зорилтыг зөвлөн батлах
4. Бөхөнтэй холбоотой төсөл, үйл ажиллагааны талаар мэдээллийг гаргаж сонирхож буй байгууллагуудад ойрын хугацаанд тараана.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Лайл Гловка (CMS-ийн гэрээний ажилтан), Том де Муленар (CITES-ийн ахмад эрдэм шинжилгээний ажилтан) нартай холбогдоно уу. Электрон хаяг: secretariat@cms.int.

Узбекистан бөхөн хамгаалах харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурав

Узбекистан улсаас Герман улсад суугаа элчин сайд, ноён Бахтияр Гулямов "Бөхөнгийн (Saiga tatarica tatarica) зохистой хэрэглээ, сэргээн нутагшуулалт" сэдэвт хамгаалахад чиглэгдсэн харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурав. Узбекистан нь Туркменистаны дараа харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурсан хоёрдох орон юм. 2005 оны 11 сард Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн талуудын 8-р хурлаар тус гэрээнд гарын үсэг зурах үйл ажиллагаа эхэлсэн. CMS-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга Роберт Хепворт хэлэхдээ: "Узбекистан нь орон нутгийн хэмжээнд харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурах CMS-ийн анхны гишүүн орон юм. Энэ үйл явдал нь бусад орнуудыг CMS-ийн гишүүн орон болоход түлхэц болно гэдэгт би итгэж байна" гэлээ.

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Бүгд найрамдах Узбекистан улсын байгаль хамгааллын улсын хорооны олон улсын хэлтсийн ажилтан Ирина Бекмирзаеватай envconf@uzsci.net холбогдох эсвэл http://www.cms.int/news/PRESS/nwPR2006/May/nw230506_saiga_signing.htm веб сайтад хандана уу.



Зураг. Бахтияр Гулямов, Роберт Хепворт нар харилцан ойлголцлын гэрээнд гарын үсэг зурж буй нь. Зургийг CMS-ийн нарийн бичгийн дарга нарын газар.

Ростовын байгалийн нөөц газрын олон улсын хуралд бөхөнгийн талаар дурдав

Оросын цөөхөн онгон зэрлэг тал хээрийн нөөц газрын нэг Ростовын байгалийн нөөц газрын 10 жилийн ойн баярт зориулсан олон улсын хурал 2006 оны 4 сарын 28-нд Орловский тосгонд болов. Орос, гадаадын 100 гаруй мэргэжилтнүүд тус хуралд оролцлоо. Хуралд тал хээрийн биологийн олон янз байдал, экологи, хамгааллын талаар илтгэлүүд тавигдсанаас бөхөнгийн хамгаалал, судалгааны талаар харилцан мэдээлэл солилцов. Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл Ростов байгалийн нөөц газрын захирал Л.В.Клец gzr@orlovsky.donpac.ru. –тэй холбогдоно уу.



Зураг. Бөхөнгийн бяцхан баримал (цаас, картон цаас). Дунд сургуулийн 5-р ангийн сурагч Желилова Алевина. Зургийг Анна Луцкекина.

Халимагт “Талын мастер” тэмцээн болов

Бүгд найрамдах улсыг хамарсан тус тэмцээн хүүхэд, насанд хүрэгчдийн байгаль орчны боловсрол, байгаль хамгаалахтай холбогдсон шашин шүтлэгийн үйл ажиллагааг нэмэгдүүлэх зорилготойгоор 2006 оны эхээр зохиогдсон. Тус тэмцээнийг БНХалимаг улсын экологийн төв төсөл, Халимагийн “Геден Шеддап Чап Чой Корвинг” Буддын шашны хийд, БНХалимаг улсын оюутны экологи-биологийн төв хамтран хэрэгжүүлэв. Байгаль орчны болон шашны хамгааллын холбоо ARS нь санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. 23 сургууль, 9 мэдээллийн байгууллагаас өрсөлдөгчид оролцлоо. Оролцогчид олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэг хийх, хүүхэд болон насанд хүрэгчдийн гар урлалын сэдвээр өрсөлдөв. “Ард түмний уламжлал, түүх, угсаатны зүй, экологи” гэсэн үндсэн сэдвийн дор тэмцээн явагдсан бөгөөд бөхөнгийн хамгааллын сэдэвтэй хэд хэдэн гар урлалын зүйл байлаа. Илүү мэдээлэл авахыг хүсвэл БНХалимаг улсын экологийн төсөл төвийн захирал Ольга Онгенова centercep@yandex.ru –тай холбогдоно уу.

Бөхөнгийн тухай кино шагнал хүртжээ

“Тал хээрийн Бөхөн-Карма” сэдэвт энэхүү киног А.Мисайлов, Д.Шпиленок нар бүтээжээ (2005 онд хэвлэгдэн гарсан “Бөхөнгийн мэдээ-2”-ийг үзнэ үү). Тус кино UNESCO/MAB-ийн веб кино тэмцээний 3-р байр эзэлсэн байна. Тус киног зохиогч нарт “Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүдээс шагнал авсан явдалд халуун дотно баяр хүргэж байна.

Хятадын телевизээр үзүүлсэн бөхөнгийн тухай мэдээлэл

2005 оны сүүлээр Хятадын хамгийн нэр хүндтэй, томоохон телевизийн компани болох ССТВ суваг Гансү мужийн Ховор амьтдыг судлах төв рүү өөрийн багийг илгээжээ. Тэд Ховор амьтдыг судлах төв болон бөхөнгийн талаар кино хийн 2006 оны 2 сарын 7-нд ССТВ-ээр үзүүлсэн байна. Тус төвд ажиллаж буй малын эмч, судлаачдаас зэрлэг байгаль дахь бөхөнгийн хамгааллын статус болон бөхөнд нүүрлэж буй аюул заналын талаар сурвалжлага хийн ярилцжээ. Энэ бол Хятадын телевизээр Ховор амьтдыг судлах төв болон бөхөнгийн талаар нэвтрүүлсэн анхны зүйл юм. Амьтдыг үржүүлж буй үйл ажиллагаанд хүмүүсийн анхаарлыг хандуулах төдий бус мөн зүйлийн талаарх мэдээлэл сурталчилгаа, түүний ирээдүйн талаар мэдээлэл өгсөн юм.

Үр бүтээлтэй хяналт шалгалт

“Охотзоопром”-ын салбар Казакстаны Кизилордагийн цагдаа, байгаль хамгаалагч нар тийм бузар муухай зүйлийг гэнэтийн шалгалтийн үеэр харна гэж төсөөлөөгүй байна. Тэд Кумкол Кизилордагийн хурдны зам дээр УАЗ-469 маркийн машиныг зогсоож 5 винтов буу, агнасан 13 бөхөнгийн оноо, шаргачин илрүүлсэн байна. Машин, винтовыг хураан улсын орлого болгосноос гадна 2.300.000 тенге (ойролцоогоор 19.000\$) торгууль тавьжээ. Бүгд Найрамдах Казакстан улсын эрүүгийн хуулийн 288 дугаар зүйл (хууль бус агнуур) ангийн дагуу эрүүгийн хариуцлагад татаад байна. Дараах сайтад хандан дэлгэрэнгүй мэдээлэл авна уу <http://saigak.biodiversity.ru/news/020306.html>.

Узбекистаны хулгайн анчинг Казахстаны хилийн харуулууд илрүүлэв

Батыс мужийн хилийн харуулууд 2006 оны 4 сард Казакстаны баруун хэсэгт бөхөнгийн хууль бус агнуурыг илрүүлж чадлаа. Узбекистаны хилээс ойролцоогоор 20 километр Казакстаны нутагт хулгайн ан хийж байсан 4 узбек иргэнийг саатуулсан байна. Тэдний машиныг шалган 11 бөхөн, нилээд хэдэн эвэр, винтов буу сумны хамт илрүүлжээ. Тус иргэдийг хариуцлагад татаад байна. Казинформын 13.04.2006 интернет мэдээнээс авав. Илүү мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар холбогдоно уу <http://www.press-uz.info/index.php?id=2452>.



Зураг. 2006.02.02. tigers.ru интернет хуудаснаас авав.

Үргэнчид хулгайн анчид бөхөнгийн мах зардаг

Узбекистаны Хорезм аймгийн Үргэнчид 2006 оны 1 сард бөхөнгийн мах худалдаанд гарсан нь тэмдэглэгджээ. Хулгайн анчид бөхөнгийн махыг холоос авчирсан нь тодорхой юм. Учир нь энэ үед улиралд бөхөн Хорезм аймгаас 600-700 километрийн алсад Устюртын тал хээрт байршдаг. Сүүлийн үед Хорезмд бөхөнгийн мах зарагдаж эхэлсэн нь Устюртын тал хээрт хулгайн ан ихсэж байгаагийн нэг илрэл юм. Зөвлөлт засаг нуран унаснаас хойш Хорезмд бөхөнгийн мах зарж байсангүй. Илүү дэлгэрэнгүй үзэхийг хүсвэл дараах сайтад хандана уу <http://news.ferghana.ru/detail.php?id=240977376138.44,1891,2022197>.

Хэвлэлийн тойм

Орос: Известия Калмыкии, дугаар 46, 2006 оны 2 сар (хураангуй)
Ирээдүйгээ буудаж байна

2005 онд Яшкул дүүрэгт 19 бөхөн хулгайгаар агнасан хэргийг эрүүгийн хариуцлагад татав. Яшкул дүүргийн Хулхута мужийн оршин суугч Ш.Х.Паризед 2004 оны 12 сарын 31-ны баярын ширээндээ бөхөн бүтнээр нь тавихаар шийджээ. “Харамсалтай” нь тэр Бүгд найрамдах Халимаг улсын Росселхознадзорын захиргааны шалгалтаар бөхөнгийн 6 оонын хамт баригдаж шинэ жилийг тэмдэглэн өнгөрөөж чадаагүй юм. Яшкул дүүргийн шүүхийн 2005 оны 5 сарын 27-ны шийдвэрээр түүнийг шоронд хорьжээ. Оросын холбооны улсын эрүүгийн хуулийн 2 дугаар хэсгийн 258 дугаар зүйлд заагдсан гэмт хэрэг хийсэн хэмээн шүүх үзэж түүнийг 1.5 жил засан хүмүүжүүлэх ангид хорьсон байна. Түүнийг мөн 36.000 рубль (ойроцоогоор 1.300\$)-ийн нөхөн төлбөрөөр торгожээ. Энэ торгууль иргэн М.Т.Бейсеновд сургаж болсонгүй. Тэр Хулхутагаас холгүй газар бөхөнгийн оноо хулгайгаар агнаж байгаад баригджээ. Түүнийг засан хүмүүжүүлэх ангид 2 жил хорих ялаар шийтгэсэн байна.

2005 оны 11 сард бөхөн агнаж байсан хулгайн анчид хэргийн газраас Хулхута, Утта тосгоны зүг зугтаж амжжээ. Хэргийн газраас 12 бөхөн олсны заримынх нь гэдэс дотрыг гарган зөөвөрлөхөд бэлэн болгосон байлаа. Эр бөхөнг ингэж олноор агнах нь популяцийн генетик олон янз байдалд хүнд цохилт болдог гэмт хэрэг юм. Бид дээрх байдалд хүмүүсийг хайхрамжгүй бүү хандаасай гэж хүсэж байна. Бөхөнгийн хувь заяанд санаа зовж байгаа хүмүүс Росселхоснадзорын захиргаанд хулгайн анчдын талаар мэдээлж байх хэрэгтэй. Хэрэв та олон жилийн турш эргэн тойрондоо бөхөн хараагүй байтал гэнэт нэг өдөр харвал бидэнд мэдэгдэнэ үү. Бүгд найрамдах Халимаг улсын Росселхоснадзорын захиргааны Охотнадзор салбарын орлогч дарга Б.Убушаев.

Казакстан: “Казакстанская правда” сонин, Дугаар 88-89, 2006 оны 4 сарын 14.



Зураг. Билчээрлэж буй шаргачин. Зургийг Жан Франсуа Лагрот

Жемийн ойролцоо бөхөн байхгүй

Энэ газраас бөхөн устсан юм шиг, магадгүй бүр үүрд устгах юм шиг санагдаж байна. Учир нь түүнийг харсан хүмүүс сэтгэлээрээ чоно мэт махчин, шуналтай болж байна. Тэд олон километр үргэлжилсэн хүний суурьшлын захаар нуугдан, Донжтау уулын хэц тагыг дамжин өнгөрч уулын ар Матайкумын элс, хилийн зурвас нутагт алс хол нүүдэллэн байршиж байна. Тэд бол бөхөн.

Гэвч өөрийгөө хамгаалах чадваргүй болсон бөхөнгийн сэг газар сайгүй тохиолддог. Аюул занал зөвхөн газраас бус агаараас бас ирдэг. Тал хээрт нисдэг тэрэг, мотоцикл, ачааны машин МАЗ, КРАЗ болон бусад “муу ёрын төмөр сүнс”-ний нүргэлэх чимээ хадаж шөнийн хядлага үргэлжилж байдаг. Толгойноосоо хөлийн хуруу хүртлээ сүүлийн үеийн дээд зэргийн-солиотой буу, шөнийн дуран, хөдөлгөөнт холбооны хэрэгслээр зэвсэглэсэн “саак” нэг нь хүрч чадах Устюртын эзлүүд уудам талд буун чимээ аниргүйг эвдэн цууриатаж байна.

Диар, Миали, Оймаит болон бусад тосгоны оршин суугчдын хэн нь ч хэдэн зуун км-ын дотор бөхөн харагдахгүй байгааг “би энэ нядлагад оролцсон” гэж хэлж зүрхлэхгүй. Бөхөнгийн бэлчээр нутаг ойрхон байдаг Атираус, Мангистау, Кызылорда аймаг болон Узбекистаны зэргэлдээх тосгоны оршин суугчид голдуу бөхөн агнадаг гэж цагдаа нар мэдээлж байна. Үүнийг дүүргийн захирагч ноён Бердихан Кемешов батлан хэлжээ. Тэрээр хэлэхдээ: “энэ амьтны тоо толгой эрчимтэй буурсан, бодит байдалд устгах аюул тулгараад байна. Өмнө нь бөхөнгийн сүрэг Жем тэр ч бүү хэл Караулкелдийн ойролцоох уст цэгээс ундаалдаг байсан. Маш том сүрэг Копа болон Заркамис тосгоныг дайран гарч байлаа. Одоо энэ амьтны ул мөр харагдахгүй болжээ” гэв. Тосгоны хүмүүс өөрийн гэрийн ойролцоо олон бөхөн харагдахад нинжин сэтгэл гаргахгүй. Хэрэв гарт нь буу байвал шууд дайран агнана. Өмнө нь бөхөнг спортын сонирхлоор агнаж байлаа гэвч бүх амьтдыг буудаад, эврийг нь тайран авч биеийг нь өмхийрүүлэн хаях нь спорт сонирхол биш. Иймэрхүү хүн мангаснууд байгаа нь айдас төрүүлж байна. Тэд өндөр албан тушаалд дуртай бөгөөд өөрийгөө хамгаалах чадваргүй бөхөнг агначихаад бардамнан сайрхана. Эврийг нь хар зах дээр зарж килограмм бүрээс 300-500 доллар цохино. Ангийн байцаагч хяналт шалгалтын хугацаандаа Байжан дүүргийн хулгайн анчдыг судалж ихэнх жижиг гарын хулгайн анчдыг баримтаар нотолжээ. Эдгээр нь Атирау, Мангистау тосгоны ажилгүй оршин суугчид юм. Өнгөрсөн оны 9 сард маш олон бөхөн агнажээ. Мангистаугийн оршин суугч Б.Нурмаганбетов, Атираугын оршин суугч К.Казибаев нараас 50 ширхэг дайз, бөхөнгийн 10 эвэр, “Урал” маркын мотоцикл хураан авч улсын орлого болгосон. Тэд нийтдээ 16 бөхөн агнаж 2 сая хүртэлх хэмжээний тенге (ойролцоогоор 17.000\$)-ийн хохирол учруулжээ. Мужийн ангийн байцаагч зөвхөн гэмт хэрэгтэн саатуулах үедээ орон нутгийн цагдаад хандаж тэдний эсрэг эрүүгийн хэрэг үүсдэг. Тус дүүрэгт ангийн байцаагч төдийгүй орон тооны бус ажилтан ч байхгүй. Өнөөдөр эдгээр хүмүүс зайлшгүй хэрэгцээтэй байгаа юм. Энэ саналыг бүс нутгийн төв рүү илгээсэн байгаа. Дүүргийн цагдаагийн ажилтны хангамж маш муу. Замын унаанд дайгдан эсвэл явганаар хяналт шалгалт хийдэг, холбоо, унаа тэрэггүй ийм ажилтан байна гээд та төсөөлөөд үз дээ. Түүний хянах талбай маш том бараг Уйл дүүргийн нутаг дэвсгэртэй тэнцэнэ. Маш сайн тоноглогдсон гэмт хэрэгтнийг хэзээ ч барих боломжгүй нь гайхах зүйл биш. Ийм өргөн уудам нутагт шалгалт хийж яваа байцаагчийг дуудан хүлээх нь утгагүй. Бөхөнгийн эврийн худалдаа хөгжин дэвшээд байгаа гол шалтгаан нь энэ. Галт тэрэгний зорчигчдод бөхөнгийн махыг амтлаад үзэхийг санал болгосон орон нутгийн “худалдаачид” хөрш зэргэлдээх аймгийн зогсоолуудад байгаа нь шөнийн анир чимээгүйг эвдэн буудаж буй мэт...

Байгуринов Зубаниш

Дэлгэрэнгүй хувилбарыг <http://www.earthwire.org/cache.cfm?aid=109992> –аас авна уу.

Эрдэм шинжилгээний өгүүлэл

Хятадад бөхөн сэргээн нутагшуулах боломжтой нөөц газрын талаар

Ли Лишү

Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг



Шиа Эрксил БНГ. Зургийг Али Канг

Шиа Эрксил байгалийн нөөц газар (цаашид Шиа Эрксил БНГ гэх) нь Хятадын Шинжан автономит муж, Борталын монголын өөртөө засах орны Алатау уулын хойд бэлд E81.43.82.33 N45.07.45.23 солбицолд оршдог. Хойд тал нь Казахстантай хиллэнэ. Тус бүс нутгийн биологийн төрөл зүйл нилээд сайн хамгаалагдсан нь урт хугацааны турш хүний нөлөө байхгүйтэй холбоотой. Ийм онгон байдал Төв Ази болон Монголын ойролцоох нутагт ховор тохиолдоно. Хятадын Казахстантай хилийн ойролцоох Алла Пасс мужийн 58 км.квадрат талбайг Шиа Эрксил БНГ-ын мэдэлд байдаг. Нөөц газрын баруун өмнөд болон өмнө орших Харитурегийн ойн 36 км.квадрат талбай мөн Шиа Эрксил БНГ-т хамаарна. Иймд Шиа Эрксил БНГ талбайгаа 220 км.квадратаас 314 км.квадрат болтол өргөжүүлсэн нь байгалийн нөөц газрын ангиллаас үндэсний байгалийн нөөц газар болох талаар хүсэлт тавихад хүргээд байна.

Шиа Эрксил БНГ-нь бөхөнгийн нүүдлийн зам болон бөхөн тогтвортой байршдаг түүхэн нутаг гэж тэмдэглэгдсэн байдаг. Зүүнгарын сав газарт амьдардаг малчид бөхөнгийн сүрэгтэй 1950-иад онд газар сайгүй дайралддаг байжээ. Гэсэн хэдий ч түүнээс хойш бөхөнгийн популяци ангийн дарамтаас болж алга болсон бөгөөд энэ нь мөн бусад зэрлэг амьтдад нөлөөлсөн. 1960-аад оноос хойш Зүүнгарын сав газар дахь бөхөн алга болсон. Шинжаны Их Сургуулийн Биологийн тэнхимийн профессор Хейнг хэлэхдээ: “Алла Пассын ойролцоох Шиа Эрксил БНГ-т шинээр тэлж буй бөхөнгийн нутаг бол нэгэн нарийн коридор юм” гэжээ. Энэхүү нутагт бөхөнгийн гол идэш тэжээл болох *Stipa*-хялгана, *Artemisia*-шарилж з[

Монгол бөхөн: ЗАХН-ийн бөхөнгийн судалгааны үр дүн


Ким ба Жоел Бергер

Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг

Зэрлэг Амьтныг Хамгаалах Нийгэмлэг (WCS)-ийн Хойд Америкийн хөтөлбөрийн судлаач Ким ба Жоел Бергер нар Монголын ШУА-ийн Биологийн хүрээлэнгийн судлаач нартай хамтран 2005 оны 10 сард баруун Монголын бөхөн, түүний амьдрах орчны тандах судалгааг хийж эхлэв. Энэхүү судалгааны зорилго нь бөхөн хамгааллыг сайжруулахад чиглэгдсэн 3-5 жилийн хугацаатай төслийн ажлыг явуулах боломжийг үнэлэх явдал байлаа. Гол зорилтууд нь: 1. Бөхөн хамгаалах талаар хувь хүмүүс болон албан байгууллагуудын одоогийн сонирхлыг тодорхойлох; 2. Биологийн мэдээлэл цуглуулах боломжийг судалж, уг мэдээлэл нь бөхөн, түүний амьдрах орчныг хамгаалахад тусалж чадах эсэхийг үнэлэх зэрэг асуудлууд байлаа. Энэхүү тандах судалгааг Зэрлэг Амьтныг Хамгаалах Монгол дахь хөтөлбөрийн дарга Аманда Файнетай хамтран явуулав.

Судалгааны баг Шарга-Манханы БНГ, Хар-Ус нуур болон Хүйсийн говийн БЦГ-уудаар хээрийн судалгааг гурван долоо хоногийн хугацаанд хийж гүйцэтгэсэн (зураг).

Судалгааны явцад 10 сарын 10-19 хооронд нийт 460 бөхөн тэмдэглэсэн. Дарви сумын бөхөн хамгаалагч (Д.Чин-Үнэн) мөн тэр хугацаанд бидний яваагүй Шарга-Манханы БНГ-ын баруун хойд хэсэгт нэмэлт 100 бөхөн тоолсон. Энэхүү судалгааны зорилго нь цаашдын хээрийн судалгаанд зориулж бөхөн амьдрах боломжит газар нутгийг үнэлэх явдал байсан бөгөөд ямар нэг тодорхой маршрутаар хийгдээгүй. Иймээс судалгааны үр дүн Монгол бөхөнгийн одоогийн популяцийн хэмжээг нарийвчлан гаргах явдал байгаагүй. Гэсэн хэдий ч судалгааны үр дүн нилээд тооны бөхөн байгаль дээр үлдсэнийг харуулж байгаа бөгөөд энэ нь бөхөн болон бөхөнгийн амьдрах орчны хамгааллын ажлыг цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй гэдгийг харуулж байна.



Зураг. Баруун Монголд бөхөн тэмдэглэсэн нутаг

Нэмж хэлэхэд судалгааны баг 4 дөрвөн долоо хоногийн турш хамгийн чухал тодорхойгүй асуултуудад хариулт олж авах, бөхөн хамгаалахад шаардлагатай мэдээллийг байгаль хамгаалах байгууллагуудын болон бөхөнгийн талаар судалгаа хийж буй гол мэргэжилтнүүдтэй уулзаж олж авлаа. Уг уулзалт Улаанбаатар болон Ховд, Говь-Алтай аймгуудад болсон ба уулзалтанд International Snow Leopard Trust, Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэн, Хар-Ус нуурын БЦГ, Дэлхийн Байгаль Хамгаалах Сан, Steppe Forward Programme, НҮБХХ-ийн Алтай Саяны төсөл, Байгаль Орчныг Хамгаалах Агентлаг, Монгол Улсын Их Сургууль, Ховдын Их Сургууль зэрэг байгууллагууд болон байгаль хамгаалагчид оролцов. Эдгээр уулзалтуудаар дараах зүйлүүд дээр анхаарав. Үүнд: 1) улирлын шилжилт хөдөлгөөн болон нүүдэл, ялангуяа хахир өвөл хэрхэн нүүдэллэдэг тухай; 2) хүн ам бага болон өндөр нягтшилтай нутагт бөхөн болон малын хоорондын идэш тэжээлийн өрсөлдөөн; 3) бөхөнгийн популяцийн байдлыг үнэлэх боловсронгуй арга зүйг боловсруулах; 4) бие гүйцсэн бөхөн болон янзаганы үхэл хоргодол түүнд нөлөөлөх хүчин зүйлс; 5) генетик; 6) бөхөнг устаж үгүй болсон нутагт нь сэргээн нутагшуулах боломж; 7) Монголын судлаачид, оюутнууд, байгаль хамгаалагчдад сургалт зохион байгуулж тэдгээрийн чадавхийг нэмэгдүүлэх, орон нутгийн хүмүүсд бөхөн хамгаалаас ашиг хүртэх боломжийг хөгжүүлэх зэрэг болно.

“Wildlife of the steppe” нийгэмлэгийн бөхөн гаршуулсан туршлага

А.Д.Липкович. Ростов мужийн “Wildlife of the steppe” нийгэмлэг

2004 онд Ростов мужийн Орлов дүүрэгт байрлах Кундученский тосгонд бөхөн гаршуулж эхэлсэн. Уг судалгааны ажил нь “Wildlife of the steppe” нийгэмлэг болон Орлов мужийн засаг захиргааны дэмжлэгтэйгээр явагдаж байна. Шинжлэх ухааны зөвлөхөөр Оросын Шинжлэх Ухааны Академийн Өмнөдийн Төв ажиллаж байгаа бөгөөд харин санхүүжилтийг “Башнефт-Юг” компаниудын бүлэг хийж байна. Халимагийн Зэрлэг Амьтны Төв (ЗАТ) дэх бөхөн үржүүлгийн газраас 2004 оны 10 сарын 9-нд таван сартай 5 эр, 5 эм нийт 10 бөхөнг ЗАТ-ын захирал Ю.Н.Арыловын удирдлагаар авчирсан.

Эдгээр амьтдыг тор ашиглан барьж, хүлээд тайвшруулах тариагаар тарьж, өвс зассан ачааны машинаар тээвэрлэн авчирсан. Бөхөнгийн янзагануудыг 15х18 м-ийн хэмжээтэй төмөр дээвэр бүхий задгай гурван чингэлэгт суллан тавьсан. Эдгээр чингэлэгнүүд нь янзага гэмтэхээс урьдчилан сэргийлсэн зууван хэлбэртэй. Ажиглалт судалгаа хийхэд зориулсан цамхагийг төв чингэлэгний ойролцоо байрлуулсан. Эхний долоо хоногт тээвэрлэлтээс болж хоёр эм янзага үхсэн. Задлан шинжилгээгээр олон тооны цус хуралт болон стрессэд орсныг тогтоожээ. Эр янзаганы гурав нь доголон: тэдгээрийн нэг нь хөл дээрээ зогсож чадахгүй байсан. Үлдсэн эм янзагануудын нэгнийх нь урд хөл хугарсан. Бидний бодлоор бол янзага барих явцад авсан гэмтлээс болсон. Учир нь амьтдыг торонд ортол нь хөөсөн бөгөөд торонд орсны дараа янзаганууд суллан тавих хүртэл зугтахыг оролдон тийчилж байсан. Амьтдыг суллан тавьсны дараа өдөр бүр ажиглалт судалгаа хийсэн. Сэрүү орж эхлэхэд янзагануудын өвлийн үс ургаж дууссан ба үүнийг биеийн жингийнх нь өөрчлөлтөөс харахад илэрхий юм. Орооны өмнөхөн 11 сарын 13-нд Халимагаас бие гүйцсэн бөхөнгийн ооно авчирсан ба уг ооныг гурван шаргагчин бүхий хашаанд суллан тавьсан. 12 сарын 27-нд ооно шаргагчингуудыг ээрэх үйлдэл үзүүлэхээ больсон. 1 сарын 12-15 ны хооронд бөхөн маллагч хөл нь хугарч эдгэрсэн шаргагчин Жейди ороонд бэлэн болсныг олж харсан. 1 сарын 12-ны өглөө тэжээл тавьж байх үед уг шаргагчин чангаар орилж байсан ба үүнд нь бие гүйцсэн ооно хариу өгч байсан. Төмөр ханаар тусгаарлагдсан залуу оононууд чангаар орилон чимээ гаргаж байсан. Жейди бага зэрэг онгорхой байсан хашааны хаалгыг эвдэхийг оролдон бөгөөд энэхүү зан төрх өмнө нь тэмдэглэгдэж байгаагүй. Хөл нь доголон нэг оононы биеийн байдал бусдаасаа тааруу байсан хэдий ч 1-р сард залуу оононууд хоорондоо мөргөлдөн тоглож эхэлсэн. Гурван шаргагчин бүгдээрээ хээл авсан. Анхны янзага 5 сарын 17-ны 18 цагт төрсөн ба 1 цаг 30 минутын дотор хөл дээрээ зогсон дуугарч эхэлсэн. Хоёрдахь янзага 5 сарын 19-нд төрсөн ба харин Жейди 6 сарын 14-нд янзагалсан.



Зургийг А.Липкович. Залуу бөхөнд тэжээл тавьж байна

2005 оны 10 сарын эхээр бөхөн үржүүлэх төвд “Степной” нөөц газраас 5 сард барьсан 5 сартай 10 янзагыг тээвэрлэн нэмж авчирсан. Шинээр авчирсан янзагануудыг халаагуур бүхий хорогдох байртай задгай талбайд тусад нь хашсан. 2005 оны 12 сард өмнөх жилийн оононууд түрэмгий зан төрх үзүүлж эхэлсэн. Тэдгээрийн нэг болох бусдаасаа мэдэгдэхүйц том биетэй ооно илт давамгайлан түрэмгийлж эхэлсэн. 12 сарын сүүлчээр хамгийн сул дорой ооно үхсэн ба задлан шинжилгээгээр цус хуралт болон шарх авсан ул мөр илэрсэн. 2005 оны 12 сарын 24-нд амьтдын биеийн байдлыг үзэхэд бүгд сайн байсан. Зургаан шаргагчинг шижлүүлэн нэг оононы хамт задгай талбайд хашсан. Ооно орооны үеийн зан төрх үзүүлсэн ба үүний нэг нь сүрэг үүсгэх явц бөгөөд харин залуу оононууд мөн л хоорондоо мөргөлдөж тоглож эхэлсэн. 2005 оны 12 сарын сүүлч гэхэд бөхөн үржүүлэх төвд нийт 14 бөхөн байлаа.

Устюртын тэгш өндөрлөг газар дахь байгалийн хийг ашиглах нь бөхөнгийн шинэ аюул занал мөн үү?

Елена Быкова¹, Александр Есипов¹, Рустам Мурзаханов²

¹Узбекийн Шинжлэх Ухааны Академийн Амьтан судлалын хүрээлэн

² “Армон” Экологийн хуулийн төв

Узбекистан улс байгалийн хийн нөөцөөрөө дэлхийд 8-р байр эзэлдэг. Нийт 2.44 триллион куб.м байгалийн хийн нөөцтэйгээс 1.7 триллион куб.м-нь Устюртад байдаг. Энэхүү тэгш өндөрлөг газар 250 зүйл сээртэн амьтад бүхий бахархмаар хосгүй байгалийн баялагтай. Эдгээрийн түлхүүр зүйл амьтдын нэг бол бөхөн юм. Энэхүү нутаг маш алслагдмал, эдийн засгийн хөгжлийн төвшин доогуур, харьцангуй бага хөндөгдсөн хосгүй экосистемтэй. Хэдий тийм ч “Арал” далайн байгалийн гамшиг нь эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг хүмүүсийн амьдралын түвшинг доройтуулах замаар улам дордуулж, улмаар ажилгүйдэл үүсч энэ нь зэрлэг байгальд халдах гол шалтгаан болсон. Ялангуяа бөхөнг хулгайгаар агнах явдал эрс ихэссэн. Гэсэн хэдий ч бөхөнгийн хувьд хулгайн ан бол дан ганц аюул занал биш юм. Орос, Узбекистаны хамтарсан төслүүдийн хэрэгжилтээр орон нутгийн эрчим хүчний салбарын хөгжил дээшилж байгаа бөгөөд энэ нь бөхөнгийн популяцид учирч болох боломжит аюул занал юм.



Тулэй хийн баазын ойролцоох хийн дэлбэрэлт. Зургийг А.Есипов

Хоёр хий дамжуулах хоолой (Төв Ази-Төв, Бухар-Урал)-г Устюртын тэгш өндөрлөг дундуур барьж байна. Кир-Куз, Тулей, Каракалпакия, Кубла-Уссур гэсэн дөрвөн хий шахуургын станц энд үйлчилдэг. Үүнээс гадна Узбекистаны үндэсний томоохон компани болох “Узбекнефтегаз”-нь Оросын гол компаниуд болох Лукойл болон Газпром-тай хамтран Устюртын тэгш өндөрлөг газарт их хэмжээний байгалийн хий олборлохоор төлөвлөж байна. Лукойл компани нь Кунградын хэсэгт хайгуул судалгаа хийхээр болсон бөгөөд хийн болон химийн цогцолбор, хоёр шахуургын станц, 200 км хийн гол хоолой болон хоёр үйлдвэрлэлийн хэсгийг 2010 он гэхэд барихаар төлөвлөж байна. Үндэсний томоохон компани болох Узбекнефтегаз болон Оросын Газпром компаниуд Устюртын тэгш өндөрлөг газар дахь хийн нөөцийг судлахад хамтран ажиллах, мөн түүнчлэн байгалийн хий тээвэрлэх тухай хоорондын гэрээнд 2002 онд гарын үсэг зурсан. Шарпат дахь хийг боловсруулах тухай гэрээнд аль хэдийн гарын үсэг зурсан. Урга, Куаниш болон Акчалакийн хий олборлох тухай дараачийн гэрээг 2006 оны дундуур байгуулахаар төлөвлөж байна. Газпром компани нь Европ руу экспортолж буй байгалийн хийн өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангахын тулд Төв Азийн хийг олборлох шаардлагатай гэнэ. Үүний тулд Төв Ази-Төвийн хий дамжуулах гол хоолойн Узбек дэх хэсгийг засварлаж Узбекистаны хий дамжуулах сүлжээг шинэчлэхээр төлөвлөж байна. 2007 оны эхээр Газпром компани хий дамжуулах хоолойн өргөтгөл ажлыг хийж эхэлнэ.

Узбекистан дахь Оросын өөр нэгэн бизнес бол өмнө нь British Trinity Energy-д харьяалагддаг байсан UzPEC LTD компани юм. Узбекнефтегаз болон UzPEC LTD компаниуд Устюртын төв хэсэгт хийн нөөцийг судлах ажлыг хийхээр төлөвлөж байсан ба ажил нь аль хэдийн эхэлжээ. Энэ бүгдээс үзэхэд Устюртын тэгш өндөрлөг газарт ойрын ирээдүйд байгалийн хийн олборлолт болон түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанууд нь хүнд дарамтыг бий болгоно. Улмаар уг бүс нутгийн биологийн олон янз байдалд асар хурдтайгаар нөлөөлж эхлэх нь зайлшгүй юм. Устюртын тэгш өндөрлөг газрын Каракалпак хэсэг бол Казахстанас нүүдэллэн ирсэн бөхөн өвөлждөг гол нутаг юм. Уг бүс нутагт газрын тос болон байгалийн олборлолт хурдацтай хөгжиж байх 1960-1970 аад оны үед хий дамжуулах хоолойнд зориулж ухсан шуудуунд бөхөн унаж үхсэн тохиолдол ихээр бүртгэгдэж, энэ нь бөхөнгийн үхэл хорогдлын дийлэнх хувийг эзэлж байсан. Геологичид газрын тос болон хийн хайгуул судалгаа хийж байх үедээ бөхөнг хулгайгаар их хэмжээтэй агнаж байсан нь тэмдэглэгдсэн байдаг. Тэр үед бөхөнгийн бүхэл бүтэн сүргийг зөвхөн зугаа болгон агнаж байсан нь харгис хядлагыг санагдуулдаг.

Одоо үед хий дамжуулах хоолойн салбаруудыг газар ухан суулгасан нь бөхөнгийн нүүдэлд тийм ч ноцтой саад хаалт биш юм. Гэсэн хэдий ч бөхөнгийн тоо толгой цөөрсөөр байгаа ба бөхөнгийн популяцийн үхэл хоргодолд нөлөөлөх бусад хүчин зүйлсийг тогтоох нь чухал юм. Бид дээр дурдсан бөхөнгийн нүүдлийн замд байрлах Урга болон Куаниши, мөн бөхөнгийн өвөлждөг газарт байрлах Шахпацийн байгалийн хийн орд газруудыг онцлон анхаарч байна. Уссур дахь бөхөнгийн популяцид байгалийн хийн олборлолт хэрхэн нөлөөлж буйг судлах нь шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд улмаар бөхөнд нөлөөлж буй сөрөг нөлөөг багасгах боломжтой. Хэрэв энэхүү сөрөг нөлөөг багасгах арга хэмжээг авахгүй бол бидний таамаглаж буйгаар эдгээр төлөвлөгдсөн төслүүдийн үйл ажиллагаагаар бөхөнгийн үрждэг, нүүдэллэдэг, өвөлждөг цөм нутгууд доройтолд орно. Үүний тулд дээрхи хий болон газрын тос олборлодог компаний ажилчид болон удирдлагуудад экологийн боловсрол олгож, байгаль хамгаалалд татан оролцуулах хэрэгтэй. Оросын Лукойл болон Газпром компаниуд байгаль орчинд анхаарлаа хандуулж, бөхөн хамгаалах үйл хэрэгт хамтран ажиллана гэдэгт бид найдаж байна.

Төслийн эргэн тойронд



Халимагийн иргэдийн амьжиргааг сайжруулах төсөл хэрэгжиж байна

Нийгэм эдийн засгийн 1990 оны хямралаас болж Халимагийн малын тоо толгой огцом буурч, хүн ам ядууралд орсон. Амьжиргааны түвшин буурсан нутгийн иргэд хулгайн ан хийхэд хүрч энэ нь бусад хүчин зүйлтэй хамтран бөхөнгийн популяцид асар муу үр дагавар авчирч аюултай байдалд орсон. Энэ нөхцөл байдлыг сайжруулахын тулд “Үхрийг Халимагийн бөхөнг хамгаалах хэрэглүүр болгох нь” сэдэвт Нэгдсэн Вант Улсын Байгаль орчны салбарын ХХАЯ-ны “Байгаль Орчны Жижиг Төслүүдийн хүрээнд санхүүжигдэж буй төслийг хэрэгжүүлж байна. Судалгааны багийг Халимагийн Зэрлэг Амьтны Төвийн захирал Юрий Арылов удирдан явуулж, Нэгдсэн Вант улсын Эзэн Хааны коллеж хамтрагчаар нь ажиллаж байна. Харин Москва дахь Британы элчин сайд уг төслийг удирдаж байна.

Дарвины санаачлага төсөл (“Бөхөнгийн мэдээ” сэтгүүлийн 2005 оны 1-р дугаарыг үз) хэрэгжиж байх үед бид “Чёрные Земли” шим мандлын нөөц газрын ойролцоо амьдардаг нутгийн иргэдээс хүмүүсийн амьжиргааг сайжруулахын тулд юу хийвэл зохистой вэ гэж асууж байсан. Орон нутгийн тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл бол мал аж ахуйг сайжруулах явдал гэж ихэнх хүмүүс хариулсан. Хөгжлийн агентлагуудын хэрэгжүүлж байсан “rotating cow” системийг ашиглан иргэдийн амьжиргааг сайжруулахаар шийдсэн. Энэхүү төслийн хүрээнд орон нутгийн иргэдийн өөрсдөө сонгосон гэр бүлүүдэд төслөөс үхэр олгосон. Хэрэв тохиролцсон хугацаанд эм тугал төрвөл түүнийг “cow bank” руу илгээж тэндээсээ дараагийн гэр бүлд тарааж өгөх замаар төслийн үйл ажиллагааг эргэлтэнд оруулсан.

Тосгоноос сонгогдсон эдгээр бүлүүд нь тэдгээрийн хэрэгцээ, шаардлага болон бөхөнг хулгайгаар агнах явдалтай тэмцэх тал дээр зөвшилцсөний үндсэн дээр сонгогдсон. Бид Яшкул дүүргийн захиргаатай хамтран уулзалт зохиож нийгэм эдийн засгийн судалгаа хийгдсэн бөхөнгийн тархац нутагт ойрхон байрладаг хоёр тосгонд уг төслийг хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй гэж үзсэн. Кулкута тосгон нь “Чёрные земли” шим мандлын нөөц газраас хойд зүгт 30 км зайтай ба харин Таван-Гашун нь нөөц газрын баруун хойд хилд ойрхон байрладаг. Тосгон бүрээс сонгогдсон нэг бүлд үнээ олгох ба саравч барих, тэжээл болон бусад шаардлагатай зүйлсийг худалдан авах, мөн мал эмнэлгийн үйчилгээ үзүүлэх тусламжаар хангагдсан. Эхний гурван жилд гарсан тугалнуудыг төсөлд хүлээлгэн өгнө. Тосгоны иргэд уг төсөлд аль хэдийн идэвхтэй оролцож эхэлсэн бөгөөд үүгээр бөхөн хамгаалал болон иргэдийн амьжиргааг сайжруулахад нөлөө үзүүлнэ гэдэгт бид итгэж байна. Энэхүү төслийн хоёрдахь бүрэлдэхүүн хэсэг нь “Зэрлэг Амьтны Төв”-д суурилсан бөгөөд төслийн үндсэн сүргийг хоёр үнээ, нэг бух бүрдүүлнэ. Сүүн бүтээгдэхүүнийг боловсруулан цагаан идээг орон нутгийн сургууль, цэцэрлэгт нийлүүлдэг. Төсөл 2007 он хүртэл санхүүжигдэх ба төслийн хугацаа дуусахад бидний буй болгосон энэхүү хөдөлгөх хүч нь цаашдын тогтвортой ирээдүйг авчрана гэдэгт найдаж байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл Халимагийн “Зэрлэг амьтны төв”-ийн төслийн зохицуулагч Ю.Арылов (kalmsaiga@elista.ru), Халимагийн Экологийн төслүүдийн төсвийн ажилтан, уг төслийн хамтрагч Ольга Обгенова (centercep@yandex.ru), Лондоны Эзэн Хааны Коллежийн Е.Ж Милнер Гулланд (e.j.milner-gulland@imperial.ac.uk) нартай холбоо байрина уу!



Төслийн газарт. Зүүн талаас: Юрий Арылов, Анна Шугалиева, Милнер-Гулланд, Цебииковийн гэр бцл. Зургийг Анна Луцкекина (зүүн); Өглөөний саам. Зургийг Юрий Арылов (баруун)



Бид ертөнцийг илүү сайн, эелдэг болгох ёстой – Халимагийн TNT төсөл

2003 оны эхээр TNT-Express компани нь Халимагийн “Зэрлэг Амьтны Төв”-ийн үйл ажиллагаанд санхүүжилт олгов. Уг санхүүжилт нь шинээр төрсөн бөхөнгийн янзаганд чанартай тэжээл тавьж өгөх, хашааг нь сунгаж янзлах, орон нутгийн иргэдийн байгаль хамгааллын талаарх мэдлэгийн сайжруулахад зарцуулагдана. Үүнээс гадна уг компани өөрсдийн үйлчлүүлэгчдийг бөхөн хамгаалалд татан оролцуулж “Бөхөнг хамгаал” сэдэвт төслийг хэрэгжүүлж байна.



TNT-Express компани нь өөрсдийн үйлчлүүлэгчиддээ “Үйлчлүүлэгчийн шударга арга хэмжээ” маягыг илгээж эргэж ирсэн маягт тутмаас 20 еврог Халимагийн “Зэрлэг Амьтны Төв”-д хандивлаж байна. Жил ирэх тутам олон тооны үйлчлүүлэгч энэхүү төсөлд идэвхтэй нэгдэж байна. Илүү мэдээ авахыг хүсвэл UNESCO/MAB-ийн Анна Луцкекина (mab.ru@relcom.ru)-тай холбоо барина уу.

Оросын бөхөнг хамгаалахад АНУ тусалж байна



Бөхөнгийн мэдээ сэтгүүлийн 2-р дугаарт нийтэлсний дагуу Америкийн "Fish and Wildlife Service" алба нь Оросын бөхөн хамгаалалд зориулж тэтгэлэг олгосон. Энэхүү тэтгэлэг нь "Чёрные земли" шим мандлын байгалийн нөөц газрын байгаль хамгаалагчдыг радио болон хээрийн багаж техникээр хангах, нөөц газрын эргэн тойронд хилийн тэмдэг босгох зэрэгт зарцуулагдана.

Энэхүү бөхөнгийн хамгааллыг сайжруулсан байгалийн нөөц газарт баруун хойд Каспий орчмын бараг бүх бөхөнгүүд ороо болон төллөлтийн үед бөөгнөрдөг. USFWS байгууллага нь "Large Herbivore Foundation" болон бусад ивээн тэтгэгчидтэй хамтран саяхан нээгдсэн Яшкулын бөхөн үржүүлэх төв дэх зочид хүлээн авах танхимын барилгыг мөн санхүүжүүлэв. Илүү мэдээлэл авахыг хүсвэл UNESCO/MAB-ийн Анна Луцкекина (mab.ru@relcom.ru)-тай холбоо барина уу.



БНГ-ын хил дээр. Зургийг Анна Луцкекина



Халимаг дахь Дарвины санаачлагын шинэ төсөл

Дарвины санаачлага нь Лондоны Эзэн Хааны Коллеж болон түүний Халимаг дахь хамтрагчидад санхүүжилт олгосноо зарласан ба үүгээр "Халимагийн бөхөн хамгаалалд олон нийтийн оролцоог үнэлэх" төслийг санхүүжүүлэх бөгөөд уг төсөл 2006 оны 5 сарын 1-нээс 2007 оны 12 сарын 31 хүртэл үргэлжилнэ. Энэхүү төслөөр өмнө нь хэрэгжүүлж байсан Дарвины төсөл болох 2003 оны 4 сараас 2006 оны 3 сар хүртэлх хугацаанд үргэлжилсэн "Бөхөн хамгааллыг түшиглэн нутгийн иргэдийн амьжиргааг сайжруулах" төслийг үргэлжлүүлэхээр болов. Уг төсөл нь бидний эхний төслийн үр дүнг үнэлж дараагийн зорилгодоо хүрэх амжилтын үндэс болсон.

Шинэ төслийн зохицуулагчаар Е.Ж Милнер Гулланд ажиллах болно. Харин Халимагийн талаас төслийн зохицуулагчаар Экологийн төслүүдийн төвийн Ольга Обгенова (centercep@yandex.ru) ажиллана. Төслийн хамтрагчаар Халимагийн Зэрлэг Амьтны Төв, "Чёрные Земли" шим мандлын нөөц газар, Дарма төв, Яшкулын сургууль, Аршаны Хүүхдийн төв болон Степной Заказник зэрэг байгууллагууд ажиллана. Доктор А.Луцкекина уг төслийн зөвлөхөөр ажиллахаар болоод байна. Энэхүү төслийн зорилго нь:

- 1/ Бөхөнгийн популяцийн экологи болон хулгайн ангийн судалгааг үргэлжлүүлж, эдгээр мэдээллийг боловсруулах мэдээллийн сан бий болгох
- 2/ Яшкул дахь бөхөн үржүүлэх төвийн үйл ажиллагаа, ялангуяа зочдын төв болон үхэр үржүүлгийн төслийг дэмжих
- 3/ Улсыг хамарсан өргөн хэмжээний, хүчирхэг боловсролын хөтөлбөрийг хөгжүүлэх, ялангуяа экскурс, экологийн клуб, хүүхдийн уралдааныг хөгжүүлэх
- 4/ Бөхөн хамгаалалд орон нутгийн иргэдийн чиг хандлагыг тодорхойлон бүс нутгуудын бөхөн хамгаалах арга замуудын хоорондын ялгааг судалж, улмаар хамгааллын үр ашигтай хэлбэрийг төлөвлөх
- 5/ Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, тараах материал ашиглан бөхөн хамгааллыг сурталчлах, ялангуяа Буддын шашны сүсэг бишрэлийг байгаль хамгаалалд ашиглах
- 6/ Нэгдсэн вант улс болон Халимаг дахь байгаль хамгаалах бүлгүүдийн хамтын ажиллагааг 2007 эхээр хөтөлбөр солилцооны шугамаар эрчимжүүлэх

Илүү мэдээлэл авахыг хүсвэл Лондоны Эзэн Хааны Коллежийн Е.Ж Милнер Гулланд (e.j.milner-gulland@imperial.ac.uk)-тай холбоо барина уу!

Бөхөнгийн талаар саяхан нийтлэгдсэн бүтээлийн тойм

В.М Неронов, Ю.Н Арылов, В.С Бадмаев, А.А Луцкекина. Тал хээрийн биологийн олон янз байдлын түлхүүр зүйлийн хамгааллын экосистемийн болон газар нутгийн хэлбэр (бөхөнгийн судалгаа). Биологийн олон янз байдалд тусгай хамгаалалтай газруудын үүрэг. Ростов мужийн Орловск тосгонд 4 сарын 26-28 нд болсон Ростовскийн БНГ-ын 10 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээ онол-практикийн хурлын бүтээл. Ростовын Их Сургуулийн хэвлэх үйлдвэр. 2006. Хуудас 74-77.

Бөхөн дээр үндэслэн энэхүү өгүүлэл нь тал хээрийн биологийн олон янз байдал, түлхүүр зүйлийг хамгаалах, тоо толгойг нөхөн сэргээхэд экосистем болон газар нутгийг хамгаалах хэрэгтэй гэж үзэж байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл Валерий Неронов (mab.ru@relcom.ru)-той холбоо барина уу!

Г.И Эрдненов, П.К Лукбанов, Б.С Убушаев, А.А Луцкекина, Е.Ж Милнер- Гулланд. "Black grounds" БНГ дахь бөхөнгийн төллөх болон орооны үеийн онцлог.

Биологийн олон янз байдалд дархан цаазат газруудын үүрэг. Ростов мужийн Орловск тосгонд 4 сарын 26-28 нд болсон Ростовскийн БНГ-ын 10 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээ онол-практикийн хурлын бүтээл*. Ростовын Их Сургуулийн хэвлэх үйлдвэр. 2006. Хуудас 344-347.

"Чёрные земли" БНГ, мөн түүний хөрш зэргэлдээ газар нутгуудад 2004-2005 онд явуулсан Дарвины санаачлага сан (Дугаар 10/028) болон ИНТАС (дугаар 03-51-3579) байгууллагуудын санхүүжүүлсэн бөхөнгийн төллөлт, орооны үеийн хээрийн судалгааны үр дүн.

Энэхүү өгүүлэл нь бөхөнгийн ороо болон төллөлт болдог газар нутгууд нь ерөнхийдөө давхцдаг ба баруун хойд Каспийн районд тархсан бөхөнгийн популяцийн 70-80% нь энэхүү нутагт төллөдөгийг харуулж байна. Илүү мэдээлэл авахыг хүсвэл Анна Луцкекина (mab.ru@relcom.ru) холбоо барина уу! *

*БНГ-ын 10 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний практик их хурлын бүтээлийг БНГ-ын захирал ноён Л.В Клез (gzi@orlovsky.donpac.ru) -ээс захиалан авч болно.